



ТАВАНТОЛГОЙ ХК

“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 16

Өмнөговь аймаг

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Тавантолгой ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийг тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 11.00 цагт Өмнөговь аймгийн Цогтцэций сум, компанийн төв байрны хурлын танхимд танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

2.1.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай танилцуулга

2.1.2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тодотгол хийж, төрийн аудитын байгууллагад мэдээлсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт

2.1.3. Компанийн 2023 оны ноогдол ашиг хуваарилах асуудалтай холбоотой ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэх

2.1.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2024 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлсүгэй.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай зарыг хавсралт 01-ээр баталж, Санхүүгийн зохицуулах хорооны баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг хавсралт 02-оор баталж, энэхүү баримт бичгийг 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах саналын хуудсыг 3 дугаар хавсралтаар баталж саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2024 оны 08 дүгээр сарын 26-ны өдрийн 11.00 цаг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Г.Цог-Өрнөхийг томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын даргаар Д.Дархантөгс, гишүүдээр С.Дарханбаатар, Д.Энхсаруул нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах комиссын даргаар компанийн Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Төрмандахыг, гишүүдээр Э.Бямбажав, Ч.Эрдэнэдорж нарыг томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлыг компанийн компанийн үйл ажиллагааны зардлаас гаргахыг гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва/-д зөвшөөрсүгэй.

12. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 11 тоот "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай" тогтоолыг хүчингүйд тооцсугай.



Г.ЦОГ-ӨРНӨХ